

## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**Аудит хийх үндэслэл:** Аудитыг Сүхбаатар аймгийн ИТХ-ын захиалга, Монгол улсын Ерөнхий аудитор 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн.

### **АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

**Нийт төсвийн 0.6 хувийг зориулалт бус зарцуусан нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй хэрэгжсэнийг харуулж байна.**

### **Аудитын нэр:**

**Сүхбаатар аймгийн Онгон сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн**

**Баруун-Урт сум  
2017 он**

## АГУУЛГА

### Аудитын тайланг бэлтгэсэн:

**Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар**

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор  
М.Нарантуяа

Аудитын менежер  
Г.Даваа

Ахлах аудитор:  
Н.Болдбаатар

Аудитор:  
А.Мөнхцэцэг  
Б.Мөнхбамбар

2017 оны 09 дугаар сарын 25-ны өдөр

Уг тайланг ААГ-ын Веб сайт-аас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал багийн утас 70512127, Газрын дарга, тэргүүлэх аудитор 70518396 дугаарын факсаар харилцана уу.

**ХАЯГ:**

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар Баруун-Урт сум 7-р баг төрийн захиргааны байр өрөөний дугаар 226 тоот

Сүхбаатар аймаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт 3-4

Товчилсон үгийн тайлбар 5

1.1 Татварын орлого 2 нэр төрөл дээр тасарсан хэдий ч төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөжээ  
1.2 Төсвийн зарцуулалттай холбоотой төсвийн байгууллагууд 51.8 сая төгрөгийн зөрчил дутагдал гаргаснаас 8.4 сая төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулжээ. 6-7

1.3 Улс орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийг НББ-д бүрэн тусгасан хэдий ч зарим төсөвт байгууллагууд хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгүй байна. 7-10

2.1 Сумын засаг даргын 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн мөрийн хөтөлбөрийн биелэлт, үндсэн чиглэлийн хэрэгжилт 94.5 хувьтай хэрэгжсэн байна. 10-11

2.2 Байгаль хамгаалах сангаас 5500.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулжээ. 11-12

2.3 ЗДТГ-ын мэргэжилтэнүүдийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг холбогдох журам, аргачлалын дагуу дүгнээгүй байна. 12

2.4 Сумын ИТХ нь хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой эрх, үүргүүдийг хэрэгжүүлж ажилаагүй байна. 12-13

3.1 Сумын ИТХ-ын гаргасан нэг тогтоол хэрэгжээгүй байна. 13-14

3.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт 50 хувьтай хэрэгжсэн байна. 14

3.3 Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. 15

3.4 Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ хийгдээгүй байна. 15

Дүгнэлт 16

Зөвлөмж 16-17

Холбогдох байгууллагын санал

Аймгийн аудитын газрын тайлбар

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

### 1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторт 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

### 2. Аудитын зорилт

Аудитын зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Үүнд:

- I. Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн
- II. Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчдын үр дүнгийн гэрээний биелэлт
- III. Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт түүнд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй байна уу

### 3. Аудитын хамрах хүрээ

Сүхбаатар аймгийн Онгон сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн баримт материал, бодлогын бичиг баримт, үйл ажиллагааны холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

### 4. Үндсэн мэдээлэл

Онгон сумын 2016 онд орон нутгийн татварын ба татварын бус орлого 104.0 сая төгрөг төвлөрч 45.5 сая төгрөг буюу 77 хувиар давж биелэсэн байна. Нийт мөнгөн хөрөнгийн 40.6 хувийг төсөл сангийн харилцах дансдын үлдэгдэл, 34.8 хувийг төрийн сангийн мөнгөн хөрөнгө, үлдэх хувийг ОНӨААТҮГ-ын үлдэгдэл эзэлж байна. Онгон арвижих ОНӨААТҮГ нь 2016 онд үндсэн 2 төрлийн үйл ажиллагаагаар 204.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллажээ.

Онгон сумын хувьд 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 төсөвт байгууллага, 5 төсөл сан, 1 ОНӨААТҮГ, 1 ТЕЗ, нийт 13 байгууллага хамрагдсанаас 2 төсөвт байгууллага, 5 төсөл сан, 1 ОНӨААТҮГ, нийт 8 байгууллагыг түүвэрт хамруулж, 4 төсөвт байгууллага, 1 ТЕЗ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан. Дээрх 5 байгууллага бүгд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна. Тус аудитаар 26.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Бүрэн биелэгдээгүй буюу хэрэгжилт дутуу төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн талаар: Актын хувьд 2015, 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2 акт, өргөдөл, гомдлоор хийсэн аудитаар тогтоосон 2 акт, нийт 43.4 сая төгрөгийн 4 актын биелэлт дутуу байна. Албан шаардлагын хувьд 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, өргөдөл, гомдлоор 1 албан шаардлага, нийт 7.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хэрэгжээгүй байна. Зөвлөмжийн хувьд 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж, Идлэг шонхор шувуу барих гадаад оронд гаргах үйл ажиллагааг зохицуулж буй хууль

тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 2 зөвлөмж, нийт 3 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна.

## **5. Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам, Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу аудитын арга зүйг мөрдөж, Сүхбаатар аймгийн Онгон сумын удирдлага болон ажилтан албан хаагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. (*Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №1-т үзүүлэв.*)

## **6. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд**

Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Соёлын тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын тухай, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Боловсролын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, НББОУС болон холбогдох бусад хууль, тогтоомжуудыг шалгуур үзүүлэлт болгож ашиглана.

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БДС	Бүрэн дунд сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НЭМ	Нийгмийн эрүүл мэнд
НББ	Нягтлан бодох бүртгэл
ААН	Аж ахуйн нэгж
МАН	Мал аж ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нийцлийн аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ӨГХ	Өргөдөл, гомдол, хүсэлт

**Дэд зорилт-1 Төсвийн болон ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн**

1

**БҮЛЭГ 1** *Төсвийн орлого давсан боловч төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулж, хөрөнгийн тооллогыг чанаргүй хэрэгжүүлсэн байна.*

**1.1 Татварын орлого 2 нэр төрөл дээр тасарсан хэдий ч төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөжээ.**

**1.1.1** Төсвийн орлогын төлөвлөгөөг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 11 сарын 19-ны өдрийн 244 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу боловсруулжээ.

**1.1.2** Онгон сумын ИТХ-аас орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 58.5 сая төгрөг буюу татварын орлогыг 38.5 сая төгрөг, татварын бус орлогыг 20.0 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан. Гүйцэтгэлээр 104.1 сая төгрөгийн орлого төвлөрч төсвийн орлого 45.1 сая төгрөгөөр давж биелэсэн байна. Төсвийн орлого нийт дүнгээрээ давсан боловч татварын орлого 3.0 сая төгрөгөөр тасарч, татварын бус орлого 48.7 сая төгрөгөөр давсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлээр хүснэгтээр харуулбал:

				/ Сая.төг /
№	Татварын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан, тасарсан дүн
<b>1</b>	<b>Урсгал орлого</b>	<b>58.5</b>	<b>104.1</b>	<b>45.1</b>
<b>2</b>	<b><u>Татварын орлого</u></b>	<b><u>38.5</u></b>	<b><u>35.4</u></b>	<b><u>3.1</u></b>
2.1	Үйл ажиллагааны орлого	3.0	3.0	0
2.2	Шууд бус орлого	25.0	22.8	-2.2
<b>3</b>	<b><u>Хөрөнгийн орлого</u></b>	<b><u>1.7</u></b>	<b><u>1.6</u></b>	<b><u>-0.1</u></b>
3.1	Бууны албан татвар	1.7	1.6	-0.1
<b>4</b>	<b><u>Бусад татвар</u></b>	<b><u>8.8</u></b>	<b><u>8.1</u></b>	<b><u>0.7</u></b>
4.1	Улсын тэмдэгтийн хураамж	5.3	5.8	0.5.
4.2	Хог хаягдлын хураамж	1.0	0	-1.0
4.3	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласаны төлбөр	0.5	0.3	-0.2
4.4	Ус ашигласаны төлбөр	2.0	2.0	0
<b>5</b>	<b><u>Татварын бус орлого</u></b>	<b><u>20.0</u></b>	<b><u>68.7</u></b>	<b><u>48.7</u></b>
5.1	Хүү торгуулийн орлого	4.0	3.5	-0.5
5.2	Бусад нэр заагдаагүй орлого	16.0	65.2	49.2

**1.1.3** Дээрх орлогын тасарсан, давсан шалтгааныг тодруулж үзэхэд :

- ❖ Ноосны урамшуулал ороогүйгээс шууд бус орлого 2.2 сая төгрөгөөр,

- ❖ 2 дугаар багийн иргэн Баруун-Урт сум руу шилжсэн, 1 иргэн бууны албан татвараа төлөөгүйгээс 0.1 сая төгрөгөөр,
- ❖ ИТХ-аас хог хаягдлын хураамжны үнэ тариф тогтоосон тогтоолыг 7 сард гаргасан боловч хавсралтыг холбогдох байгууллагад өгөөгүйгээс 1 сая төгрөгөөр,
- ❖ ОНХС-аар төлөвлөгдсөн ажил хийгдээгүй, мөн орон нутгийн иргэдийн бүтээн байгуулалт багассанаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр,
- ❖ Сумын цагдаа, төлөөлөгч сургуульд суралцахаар явж, шилжилт хөдөлгөөн хийсэнтэй холбоотойгоор хүү торгуулийн орлого 0.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

**1.1.4 Харин улсын тэмдэгтийн хураамжийн өмнөх оны үлдэгдлийг төвлөрүүлснээр 0,5 сая төгрөгөөр, БОАЖЯ-наас 9 идлэг шонхор барих зөвшөөрөл олгосноор нэр заагдаагүй орлого 49.2 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн байна**

**1.2 Төсвийн зарцуулалттай холбоотой төсвийн байгууллагууд 51.8 сая төгрөгийн зөрчил дутагдал гаргаснаас 8.4 сая төгрөгийн төсвийг зориулалт бус зарцуулжээ.**

**1.2.1 Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг батлагдсан төсөв, төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, төсвийн зарлагын гүйлгээ, журнал, дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн анхан шатны баримт материалтай тулган баталгаажуулахад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:**

**1.2.2 Сумын ИТХ:** Сумын ИТХ-ын ГХУС арга хэмжээнд төсвөөс 1213.9 мянган төгрөг зарцуулжээ. Хууль тогтоомжид заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд уг төсвийг зарцуулах байтал сумын ИТХ-ын дарга, хэсгийн төлөөлөгч нар байгууллагын дотоод үйл ажиллагаа болон хэрэг шалгах ажлын тээвэр шатахуунд төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Очирпүрэв нь өвчтэй байх хугацаандаа нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авчээ. Гэтэл өвчтэй байсан хугацааныхаа цалинг бодуулж 943.5 мянган төгрөг давхардуулан авсан зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн учир төлбөрийн акт тогтоов.

**1.2.3 Бүрэн дунд сургууль:** Хичээл үйлдвэрлэлийн зардлаас ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, шинэ жилийн хүүхдийн бэлэг, эцэг эхчүүдэд тэмцээний шагнал, ажилчдад тэргүүний ажилтаны дагалдах шагнал, ажилчдын хүүхдийн бэлэг, аж ахуйн материал худалдан авах зэрэгт 4243.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулжээ. Эдгээр зөрчлийн 650.0 мянган төгрөгт төлбөрийн акт, 3593.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулах, цаашид давтахгүй байх чиглэлээр албан шаардлага хүргүүлжээ. Үдийн цайны санхүүжилтээс хэмнэгдсэн төсвийг хүнсний материал бэлтгэн оны эцэст үлдэгдэлээр илэрхийлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7, 45.2 дахь заалтыг зөрчиж байна. Батлагдсан төсвөөс хэмнэгдэн үлдсэн төсвийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлж байхаар Төсвийн тухай хуульд заасан. Иймд бараа материал бэлтгэсэн хэмжээгээр энэ оны төсөв хэмнэгдэж байгаа тул 2439.9 мянган төгрөгийн санхүүжилтийг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоолоо. Төслөөр физикийн кабинет байгуулахад шаардлагатай багаж тоног төхөөрөмж, хичээлийн

хэрэглэгдэхүүн бэлтгэхдээ 2869.0 мянган төгрөгийг бэлнээр зарцуулсан нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2, 6.3 дахь заалтыг зөрчсөн байна. Дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр албан шаардлага өглөө.

**1.2.4 Сум дундын эмнэлэг:** Хөтөлбөр арга хэмжээний зардлаас зарцуулсан 894.3 мянган төгрөгийн ажил гүйлгээнд хуурамч баримт бүрдүүлэн төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 5.1.4,13.1,13.2 дахь заалтуудыг зөрчсөн учир төлбөрийн акт тогтоов. Ажилчдад олгосон 4204.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалингаас НДШ-ийг суутган тооцож шилжүүлсэн боловч НД-ийн байгууллагын цахим программд албан хаагч нэг бүрээр шивж баталгаажуулаагүй байна. Мөн 30139.5 мянган төгрөгийн эм боох материалыг орлого авч, зарлага болгохдоо нэгжийн үнэ, өртөг,тоо хэмжээ нэр төрлөөр санхүүгийн программд бүртгэлгүй бөөн дүнгээр илэрхийлсэн зөрчил дутагдал илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын хавсралт НББ-ын тухай хуулийн 13.1, 13.2 дахь заалтыг тус тус зөрчжээ.

**1.2.5 Сумын Хүүхдийн цэцэрлэг:** Хоолны зардлыг түүвэрлэн норм нормативтай харьцуулахад материаллаг зөрүү гараагүй боловч хоолны материалыг илүү, дутуу олгох, норм, нормативаар боддоггүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Мөн няравын тайлангийн хүүхэд өдөрлөг, багшийн ирцийн бүртгэлүүд зөрүүтэй бүртгэгдсэн дутагдал гарсан.

**1.2.6 Соёлын төв:** Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 1900.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 390.0 мянган төгрөг төвлөрч 1510.0 мянган төгрөгөөр тасарчээ. Үзвэр үйлчилгээний орлогыг тооцож оруулсан талаар ямар ч баримт, материал байхгүй байна. Соёлын байгууллага нь өөрийн гэсэн тасалбар, төлбөр тооцоо хийсэн анхан шатны баримтаар үйл ажиллагааныхаа орлогыг нотолж баримтжуулаагүй байна. Мөн орлого тасарсан, түүнд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зэрэг зохион байгуулалтын дутагдлууд илэрсэн.

**1.2.7 ЗДТГ:** Боловсролын нягтлан бодогчоор ажиллаж байсан Г.Цолмонг бүтцийн өөрчлөлтөөр ажилд томилолгүй, ажлаас чөлөөлсөн шийдвэр нь буруу болохыг Сүхбаатар аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тогтоож ажилгүй байсан хугацааны цалинг олгох шийдвэр гарсан. Цалингийн сангаас уг нөхөн олговорт 2627.4 мянган төгрөг зарцуулсан бөгөөд ажлаас үндэслэлгүй халсан, буруу тушаал шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар нөхөн төлбөрийг төлүүлж, төсвийг хохиролгүй болгох чиглэлээр хуулийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Иймд буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар уг нөхөн төлбөрийн төлүүлэх нэхэмжлэлийг шүүх хяналтын байгууллагад шилжүүлж, төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэв. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 41.2.2, 45.2.4 дэх заалтуудыг зөрчсөн байна. Сумын ЗДТГ-ын төсвийн зардлыг тулган баталгаажуулахад 163.2 мянган төгрөгийн согтууруулах ундаа худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ. Дээрх зөрчил нь “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 7.9 дэх заалтыг зөрчсөн учир төлбөрийн акт тогтоов. Сумын ЗДТГ-ын бүтэц орон тооны хувьд Монгол улсын ЗГ-ын 2015 оны 425 тогтоол /“Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоох тухай”/–оор 3001-5000 хүртэл хүн амтай суманд 15 орон тоотой байхаар тогтоосон. Гэтэл тухайн сумын ЗДТГ нь 16



орон тоотойгоор ажиллаж байна. Энэ нь ЗГ тогтоолыг зөрчин 1 орон тоогоор илүү ажиллаж байгаа нь уг тогтоолын заалттай нийцэхгүй, зөрчигдөж байна.

**1.2.8 Онгон арвижих ОНӨААТҮГ** газар нь 2016 онд 240.2 сая төгрөгийн борлуулалтын орлого орж 191.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарч 48.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Цалин, тээвэр шатахуун, тээврийн хөлс, аж ахуйн материалын зардлыг түүвэрлэн аудит хийхэд 200.0 мянган төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан зөрчил дутагдал илэрсэн. Уг зөрчилд төлбөрийн акт тогтоов. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг НББОУС-т болон Санхүү, эдийн засгийн сайд, үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын дагуу хөтлөөгүй байна.

**1.2.9** Дээрх алдаа зөрчлүүд нь “Төсвийн тухай” хуулийн 7.7<sup>1</sup>, 16.5.5<sup>2</sup>, 41.2.2<sup>3</sup>, 45.2<sup>4</sup> “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 5.1.4<sup>5</sup>, 13.1<sup>6</sup>, 13.2<sup>7</sup> “Хөдөлмөрийн тухай” хуулийн 49.1<sup>8</sup>, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 7.9<sup>9</sup> Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2, 6.3 зэрэг заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **1.3 Улс орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжсэн төсөл хөтөлбөрийг НББ-д бүрэн тусгасан хэдий ч зарим төсөвт байгууллагууд хөрөнгийн тооллыг чанартай хийгээгүй байна.**

**1.3.1** Төсөвт байгууллагууд нь өмч хамгаалах байнгын комиссын шийдвэрийг үндэслэн байгууллагын даргаар тушаал гаргуулан хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна. Үүнд :

- ✓ Нийт 68.9 сая төгрөгийн хөрөнгийг актласан,
- ✓ Тооллогоор илэрсэн 46.8 сая төгрөг, худалдан авсан 1.1 сая төгрөг, хандив тусламжаар ирсэн 6.4 сая төгрөг, ОНХС-гаар бэлтгэсэн 72.0 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авсан,
- ✓ Данс хооронд шилжүүлсэн 22.8 сая төгрөгийн хөрөнгийг хөдөлгөөнийг хийсэн байна.

**1.3.2** Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 64.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаар 399.7 сая төгрөг, Өвсний үндэс хөтөлбөрөөр 160.0 сая төгрөг нийт 623.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгажээ. Үүнд:

<sup>1</sup> энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсөв захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ

<sup>2</sup> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

<sup>3</sup> батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

<sup>4</sup> төсвийн захирагчийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэнд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ

<sup>5</sup> үнэн зөв байх

<sup>6</sup> Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно

<sup>7</sup> Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

<sup>8</sup> Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно

<sup>9</sup> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно.

/Сая.төг/

№	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	УТХО	ОНХС	Төсөл хөтөлбөрөөр
1	ЗДТГ	04 шугам, WiFi		79.7	
2	Сум дундын эмнэлэг	Багаж тоног төхөөрөмж, түргэн тусламжийн машин	38.6		
3	Цэцэрлэг	Эд хогшил, барилгын өргөтгөл	9.6		160.0
4	Бүрэн дунд сургууль	Физикийн лаборатори, эд хогшил	15.8		
5	Соёлын төв	Барилгын засвар		320.0	
	Нийт дүн		64.0	399.7	160.0

1.3.3 Төсөвт албан газруудын хөрөнгийг түүвэрлэн тоолж, тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Хүүхдийн цэцэрлэгт хандиваар ирсэн зурагт 1ш, хивс 1ш, хатаагч 1ш, шүүгээг данс бүртгэлд тусгаагүй, данс бүртгэлээс хасагдсан /хүүхдийн сандал 100ш, ширээ 2ш / хөрөнгүүдийг акталж устгалгүй ашиглаж байгаа
- Соёлын төвд хандиваар өгсөн 3 морин хуур, 1 даралтад хөгжим данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

Байгууллагуудын тооллогын комисс эд хөрөнгийг биетээр тоолоогүй, зөвхөн НББ-ийн программаар хөрөнгийн жагсаалтыг гаргаж гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Ихэнх төсөвт байгууллагуудын тооллогын комисс ажлаа хангалтгүй гүйцэтгэсэн, тооллогын чанар үр дүнд төсвийн захирагч нар хяналт хийгээгүй нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 72 зүйлийн 4.1<sup>10</sup>-д заасан заалт зөрчигдсөн байна.

1.3.4 Мөн Онгон Арвижих ОНӨААТҮГ нь хөрөнгийн тооллого хийгээгүй, ИТХ, Соёлын төв, Онгон Арвижих ОНӨААТҮГ–д нь өмч хамгаалах байнгын комисс байгуулаагүй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 12.2<sup>11</sup>, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 31.4<sup>12</sup>-д заасан заалтыг хангалтгүй хэрэгжснийг харуулж байна.

2

**Дэд зорилт-2 : Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын ажилчдын үр дүнгийн гэрээний биелэлт**

## БҮЛЭГ 2

Сумын ЗДТГ-ын мэргэжилтэнүүд үр дүнгийн гэрээгээ холбогдох журам, аргачлалын дагуу төлөвлөөгүй бөгөөд Төсвийн захирагч хяналт шинжилгээ хийж, дүгнээгүй байна.

<sup>10</sup> Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах

<sup>11</sup> Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ

<sup>12</sup> худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх

## **2.1 Сумын засаг даргын 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн мөрийн хөтөлбөрийн биелэлт, үндсэн чиглэлийн хэрэгжилт 94.5 хувьтай хэрэгжсэн байна.**

2.1.1 Сумын 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг 8 зорилтын хүрээнд 143 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг заалт тус бүрээр үнэлгээ хийхэд нийт 143 заалтаас 00 үнэлгээтэй буюу биелэгдээгүй заалт 5, 50 хувь биелэсэн 2 заалт, 70-80 хувь биелэсэн 4 заалт, 90-95 хувь биелэсэн 8, 100 хувь биелэсэн 124 заалт байна. 2016 оны сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 94,5% -ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, аж ахуйн нэгж болон малчин иргэдтэйгээ хамтарч ажиллаагүйгээс доорх арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, илрүүлсэн гэмт хэрэгт нотолгооны үүрэг гүйцэтгэх зорилгоор сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгж, төсөвт байгууллагуудыг өөрсдийнх нь зардлаар камержуулах тухай ИТХ-ын тогтоолыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах
- Мал сүрэгт үзлэг ангилалт хийхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавин ажиллах
- МАА-г эрчимжүүлэн нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малчид, мал бүхий иргэдийн захиалгын дагуу зохиомол хээлтүүлгийг хийх
- Сум бүр гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд хүртээмжтэй дуут дохиотой болох
- МУ-ын хэмжээнд орон даяар 2016.02.15 өдрөөс мөрдөгдөж эхлэх дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх үйл ажиллагаа болон замын хуудас, дагалдах бичгийн талаар ард иргэдэд сурталчилах, үнэт цаасаар хангах ажлыг орон нутагтаа зохион байгуулах

2.1.2 Харин 2017 оны эхний хагас жилийн байдлаар засаг даргын мөрийн хөтөлбөр болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 62.2 хувьтай байна. Үүнээс төлөвлөсөн арга хэмжээний 31 заалт биелээгүй, 20-60 хувийн биелэлттэй 36 заалт байгааг цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна. Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан хэрэгжээгүй заалтууд нь төсөв хөрөнгө шаардсан, судалгаа тооцоог бодитой боловсруулаагүй, үндэслэл муутай төлөвлөлттэй холбоотой байна. Иймд мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийг боловсруулах үйл ажиллагааг сайжруулж, эдийн засгийн судалгаа шинжилгээнд үндэслэн төлөвлөх шаардлагатай юм.

## **2.2 Байгаль хамгаалах сангаас 5500.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулжээ.**

2.2.1 Мал хамгаалах сан: Тайлант онд эхний үлдэгдэл 2007,5 мянган, 7751,5 мянган төгрөгийн орлого төвлөрч 6803,8 мянган төгрөгийн зардал гарч 2955,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангийн ажил гүйлгээг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад үлийн цагаан огтоно устгах зардалд 5844.0 мянга, малын түүвэр судалгаа бусад зардалд 959,8 мянган төгрөгийн зарцуулалт гарсан байна.

2.2.2 Сум хөгжүүлэх сан: Сум хөгжүүлэх сангаас 7 төсөл арга хэмжээнд 50000.0 мянган төгрөгийн зээл олгож, зээлийн гэрээний эргэн төлөлтөнд 89723.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Зээлийн гэрээний эргэн төлөлт дутуу төвлөрүүлсэн

26805.8 мянган төгрөгийг 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон байна. 2016 онд зайрмаг, талх, нарийн боов, төмөр эдлэл, суран эдлэл, дугуй засвар зэрэг чиглэлээр авсан төслийг газар дээр очиж үзэхэд төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу хэрэгжүүлсэн байна.

**2.2.3 Байгаль хамгаалах сан:** Тайлант онд оны эхний үлдэгдэл 8961.4 мянган төгрөг, 33941.6 мянган төгрөгийн орлого орж, 10343.2 мянган төгрөгийн зарлага гарч, ан амьтны нөөц ашигласны төлбөрт 25600.0 мянган төгрөгийг ерөнхий орлогын данс руу төвлөрүүлж 6959.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус сангийн зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган баталгаажуулахад Хавиргын булгийн эхийг засварлах, сэргээхэд зориулж 5500.0 мянган төгрөгийн төсөл бичиж 3600.0 мянган төгрөгийг бэлнээр, 1900.0 мянган төгрөгийг Ник ХХК-руу шилжүүлсэн боловч үндсэн баримтын бүрдэлгүй, хуурамч баримт бүрдүүлэн юунд зарцуулсан нь тодорхойгүй ажил гүйлгээг гаргасан байна. Энэ алдаа зөрчлийг аймгийн Цагдаагийн газарт шалгуулахаар шийдвэрлэлээ. Уг сангаас 4939.0 мянган төгрөгийг бэлнээр гаргаж бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, хүлээн авсан, хүлээлгэн өгсөн кассын орлого, зарлагын баримт байхгүй захиран зарцуулсан нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2, 6.3 дахь заалтыг зөрчсөн байна.

### **2.3 ЗДТГ-ын мэргэжилтэнүүдийн үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг холбогдох журам, аргачлалын дагуу дүгнээгүй байна.**

2.3.1 Сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээг холбогдох аргачлал дагуу төлөвлөж, үнэлгээ хийгдээгүй байна. Санхүүгийн албаны дарга, Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Төрийн сангийн төлөөлөгч, Дотоод ажил хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн, Хүн ам зүй, нийгмийн хамгааллын бодлогын мэргэжилтэн, Газрын даамал, Байгаль орчин аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн зэрэг нийт 8 албан хаагч үр дүнгийн гэрээ байгуулжээ. Харин зарим мэргэжилтэний ажлын байрны тодорхойлолтыг боловсруулаагүй, баримт бичгийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үр дүнгийн гэрээг байгуулж, үнэлээгүй байна.

2.3.2 Гэрээ байгуулсан мэргэжилтнүүдийн хувьд 61 зорилтын хүрээнд нийт 204 ажил үйлчилгээг 2016 оны үр дүнгийн гэрээндээ тусгаж ажилласнаас 4 мэргэжилтэний 78 ажил үйлчилгээний гэрээний биелэлтийг дүгнэсэн байна. Сумын ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь төрийн бодлого, чиглэл үр дүн муутай хэрэгжиж байгааг харуулж байна. Мөн Сумын ЗДТГ-ын дарга 3-4 удаа солигдсон, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх явц хангалтгүй байгаа нь нөлөөлжээ.

### **2.4 Сумын ИТХ нь хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой эрх, үүргүүдийг хэрэгжүүлж ажилаагүй байна.**

2.4.1 Онгон сумын төсөвт байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, дэвшүүлсэн зорилго зорилтыг үр дүнгийн гэрээний биелэлт, ажлын төлөвлөгөө, тайлан болон бусад холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийв. Үүнд:

- **ИТХ:** 2016 онд сумын ИТХ-аас тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан эсэх тодорхойгүй мөн сумын хэмжээнд гаргасан зорилго зорилтгүй байна. Сумын ИТХ нь хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой эрх,

үүргүүдийг хэрэгжүүлэх ёстой байтал ямар ажил төлөвлөсөн, ирээдүйг яаж харж байгаа нь тодорхойгүйгээр урсгалаараа явж байна гэдэг зохисгүй. Иймд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих, төсөв хөрөнгийг үр ашигтай батлах, үндсэн чиглэлийн биелэлтэд онцгойлон ач холбогдол өгөх, сум орон нутгийн хөгжлийг түүчээлэгч байх зэрэг нутгийн өөрөө удирдах ёсны манлайлалыг үзүүлэх нь зүйтэй юм.

- Бүрэн дунд сургууль: 2016-2017 оны хичээлийн жилд “Эх хэлээ эрхэмлэгч хүүхэд”, “Цагийг үр бүтээлтэй ашигладаг хүүхэд”, Эрүүл бие бялдартай хүүхэд” гэсэн зорилгын хүрээнд 9 зорилт дэвшүүлэн ажилласан байна. Зорилго зорилтоо биелүүлэх чиглэлээр сургалтын менежер болон багш ажилчид ажлын төлөвлөгөө гарган ажилласан хэдий ч Боловсрол соёл урлагын газраас үнэлсэн чанар, тоон болон хөндлөнгийн үнэлгээгээр бүрэн дунд сургуулийн хэмжээгээр 74.27 оноо буюу С үнэлгээ авч дүгнэгдсэн байна. Иймд багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, заах арга зүйг тасралтгүй сайжруулах, багш нарын багаар ажиллах үйл ажиллагааг дэмжих, хүүхэд бүрийн сурлагын амжилтыг ахиулахад багшийн оролцоог нэмэгдүүлэх, зорилго зорилтоо хэрэгжүүлэх хүрээнд эцэг эх, орон нутгийн иргэд байгууллагуудтай үр дүнтэй харилцаа тогтоон, хамтран ажиллахыг дэмжиж, санаачилгатай ажиллах шаардлагатай байна.
- Хүүхдийн цэцэрлэг: Үндэсний болон орон нутгийн хөтөлбөрүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан 2016-2017 оны хичээлийн жилд 6 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Боловсрол соёл урлагын газраас үнэлсэн чанар, тоон болон хөндлөнгийн үнэлгээгээр хүүхдийн цэцэрлэгийн хэмжээгээр 75.69 оноо буюу С үнэлгээ авч дүгнэгдсэн байна.
- Эрүүл мэндийн төв: Тус эмнэлэг нь “Хүн амд НЭМ-ийн болон эмнэлэгийн тусламж үйлчилгээг дэвшилтэт технологийг ашиглан чанартай үзүүлж, эмнэлэгийн эмч ажилчдын ёс зүйг эрхэмлэн үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд оршино” гэсэн зорилго дэвшүүлжээ. Зорилгын хүрээнд 3 зорилт дэвшүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажилласан байна. Дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2016 онд давхардсан тоогоор 8536 хүнд амбулаторийн үзлэг хийж, 4755 ор хоног ашиглаж, 636 хүн хэвтэн эмчлүүлж, багаас ирсэн 724 дуудлаганд үйлчилгээ үзүүлжээ. Ажилчин нэг бүртэй үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ хийж жилийн эцэст дүгнэн, төсвийн захирагч Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан ч оны эцэст үр дүнгийн гэрээгээ дүгнүүлээгүй байна. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийт 11 хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

3

**Дэд зорилт-3: Хууль тогтоомж, эрх зүйн актын биелэлт түүнд тавьж буй дотоод хяналт үр дүнтэй байна уу**

**БҮЛЭГЗ**

*Зарим төсөвт байгууллагууд дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй, төсөвт байгууллагад санхүүгийн дотоод хяналт хийгдээгүй байна.*

**3.1 Сумын ИТХ-ын гаргасан нэг тогтоол хэрэгжээгүй байна.**

3.1.1 Тайлант онд Сумын ИТХ-аас 33 тогтоол гарсанаас үйлчилгээний үнэ тариф тогтоосон 1 тогтоол хэрэгжээгүй байна. Нийт тогтоолын 42.4 хувийг шагнал, 21.2 хувийг сонгуультай холбоотой, 36,4 хувийг үйлчилгээний үнэ тариф болон орон нутгийн ханш тогтоох, гудамжны хаягжуулалт, наадмын комисс томилох зэрэг бусад тогтоолууд эзэлж байна. Харин хуулиар тодорхойлсон чиг үүргүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байна. Тухайлбал:

- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгсөн талаарх ажил хийгдээгүй
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлаагүй
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх журам, төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг тогтоох чиг үүргүүдийг хэрэгжүүлээгүй байна.

Сумын ИТХ хуулиар тодорхойлсон үүргээ бүрэн хэрэгжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагааг хангах зэрэг зохион байгуулалтын өөрчлөлт хийх шаардлагатай байна.

3.1.2 Сумын Засаг дарга 2016 онд цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, цэрэг татлага, аж ахуй нэгж байгууллага, орон нутгийн өмчийн улсын тооллого явуулах, газар өмчлөл, ажлын хэсэг томилох, үнэлгээний хороо, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн анги байгуулах, уулзалт уралдаан зохион байгуулах, хүндэтгэл, мөнгөн тэтгэмж олгох, гоц халдварт өвчин, сэг зэм устгах болон цаг үеийн асуудлуудтай холбоотой 102 захирамж гаргаж, түүний хэрэгжилтийг зохион байгуулжээ.

№	Захирамжийн утга	Тоо
1	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, цэрэг бүртгэл	3
2	ЗД-ын зөвлөл байгуулах	1
3	Газартай холбоотой	18
4	Мөнгөн тэтгэмж, хөрөнгө гаргах тухай, дэмжлэг, хүндэтгэл үзүүлэх, халамжийн тэтгэмж	21
5	Ажлын хэсэг томилох, мэргэжлийн анги байгуулах	9
6	Нэхэмжлэгч томилох	2
7	Үнэлгээний хороо, тусгай зөвшөөрөл	4
8	Гоц халдварт өвчин, сэг зэм устгах	5
9	Тооллого, тээврийн хэрэгслэлийн үзлэг	4
10	Уулзалт, уралдаан зохион байгуулах	3
11	Бусад	32
	<b>Бүгд</b>	<b>102</b>

### 3.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлт 50 хувьтай хэрэгжсэн байна.

3.2.1 Өмнөх аудитиар өгсөн 1 албан шаардлага, 2 төлбөрийн актын биелэлтийг холбогдох албан тушаалтнаар гаргуулж, 1 албан шаардлага, 2 төлбөрийн акт хэрэгжээгүй байна. Хэрэгжилт хангалтгүй байгаа 1 албан шаардлагын удирдлагын зөвлөлийн хурлаар оруулж хүчингүй болох, 2 төлбөрийн актыг хэрэгжилт хангалтгүй, хугацаа хэтэрсэн тул шүүхийн байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна.

### 3.3 Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

2016 онд Сумын ИТХ, ЗДТГ-д ирсэн нийт 28 санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Өргөдөл гомдлыг хууль тогтоомжид заасны дагуу иргэдээс хүлээн авсан	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн	Үүнээс:			
				Ажилд орох	Ажлаас чөлөөлөх	Эд хөрөнгө, газар холбоотой	Цалин хөлс, нэмэгдэл
1	ИТХ	7	7	4	2	1	
2	ЗДТГ	21	21	16	2	1	2
	Бүгд	28	28	20	4	2	2

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүртгэн, сумын ИТХ болон ЗД өөрийн эрхлэх асуудлын хүрээнд, хуулиар хүлээсэн чиг үүрэгт нь хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд хугацаанд нь мэдэгдэл өгч ажилласан байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой гомдол гараагүй 100 хувийн биелэлттэй байна.

### 3.4 Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ хийгдээгүй байна.

3.4.1 Сумын бүрэн дунд сургууль, Цэцэрлэг, Сум дундын эмнэлэгүүд төсвийн шууд захирагчийн шийдвэрээр дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулан хяналт хийх төлөвлөгөөг батлуулан жилд байгууллагын үйл ажиллагаанд 2-4 удаа хяналт хийж тайлагнасан байна. Шалгалтаар дараах нийтлэг үйл ажиллагаанд хяналтыг хийсэн байна. Үүнд:

- **Бүрэн дунд сургууль:** Багш нарын цаг ашиглалт, дотоод журмын хэрэгжилт, үдийн цай, байрны хүүхдийн хоолны аюулгүй байдал, багш нарын бичиг баримтын хөтлөлт, Иргэний боловсрол хичээлийн үр дүн, сургууль орчин анги танхимын цэвэрлэгээ, сурагчдын ирц, анги дэвших болон төгсөлтийн шалгалтын давтлагын явц ..гэх мэт
- **Цэцэрлэг:** Багш ажилчдын ажлын цаг ашиглалт, бичиг баримтын хөтлөлт, хүүхдийн дунд хөтлөгдөх судалгаа, ажлын байрны тохижилт, эрүүл ахуй, хоол хүнсний хадгалалт ..гэх мэт
- **Сум дундын эмнэлэг:** Эрүүл мэндийн хуулийн хэрэгжилт, эм тарианы зарцуулалт, эмч эмнэлэгийн ажилчдад олгох нормын хувцасны хангалт, вакцины хадгалалт хамгаалалт, товлалтод тавих хяналт, түгээмэл үйлдлийн стандартад тавих хяналт, байгууллагын орчны тохижилт, багаж төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, эрүүл ахуй, хүнсний тухай хуулийн хэрэгжилт зэрэгт хяналт шалгалт хэрэгжүүлжээ.

3.4.2 Уг шалгалтаар гарсан алдаа зөрчлийг холбогдох нэгжүүдэд үүрэг өгөн тодорхой ажлыг зохион байгуулж зөрчлийг арилгасан байна. Харин бусад байгууллагууд дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй, түүнчлэн бүх байгууллагуудад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн боловч зарим зорилтын хэрэгжилт хангалтгүй, нийт төсвийн 0.6 хувийг зориулалт бус зарцуулсан, төсөл санг эрх зүйн актын дагуу зарцуулаагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэж, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлжээ.

### ЗӨВЛӨМЖ

#### ИТХ

- ❖ Сумын ИТХ нь хууль тогтоомжоор тодорхойлсон тодорхой эрх, үүргүүдийг хэрэгжүүлэх, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих, төсөв хөрөнгийг үр ашигтай батлах, үндсэн чиглэлийн биелэлтэд онцгойлон ач холбогдол өгөх, сум орон нутгийн хөгжлийг түүчээлэгч байх зэрэг нутгийн өөрөө удирдах ёсны манлайлалыг хэрэгжүүлэх.
- ❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байх.

#### Сумын засаг даргад:

- Төсөвт байгууллагын дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээг зохих журмын дагуу дүгнэж, ажлын уялдаа холбоог дээшлүүлж ажиллах
- Төсөл сангаас их хэмжээний бэлэн мөнгө гаргах явдлыг хязгаарлаж, бэлэн мөнгөний зарцуулалтын баримтын бүрдлийг хангаж ажиллах
- Төсөвт байгууллагуудын хөрөнгийн тооллогыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу бодитой, чанартай хийж, хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах.
- Өмнөх аудитаар өгсөн биелэгдээгүй СБР-2015/05-СГ 1/16, ААГ-2016/01-ӨГХ-1/38 тоот актуудыг шүүхийн байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх

#### ЗДТГазарт:

- Мэргэжилтнүүдийн үр дүнгийн гэрээнд тусгагдсан ажил, үйлчилгээг оновчтой төлөвлөж, гэрээгээ дүгнэхдээ шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг үнэлж дүгнэх
- Монгол Улсын засгийн газрын 2015 оны 425 дугаар тогтоолд заасны дагуу орон тооны хязгаарт багтаан ажиллаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байх



### **Сум дундын эмнэлэгт**

- Ажилчдад олгосон үр дүнгийн урамшуулалт цалинг НД-ийн цахим программд нөхөж оруулан, албан хаагч нэг бүрээр шивж залруулах.
- Хөтөлбөр арга хэмжээний зардлыг нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулж, үр ашгийг дээшлүүлэх.

### **Соёлын төв:**

- Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөний дагуу төвлөрүүлж, үнэт цаасны тооцоог сар бүр хийж үлдэгдэлийг дарга, нягтлан бодогч, няравын гарын үсгээр баталгаажуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах

### **Хүүхдийн цэцэрлэг:**

- Хүүхдийн ирцийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулж, хүүхдийн хоолны материалыг норм, нормативаар олгож байх.

### **Онгон арвижих ОНӨААТҮГазар:**

- Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг НББОУС-т болон Санхүү, эдийн засгийн сайд, үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын дагуу хөтлөж, залруулга хийх

**Байгууллагаас ирүүлсэн санал:**



СҮХБААТАР АЙМГИЙН  
ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
22090 Хавирга, Онгон сум

2017-10-18 № 011/16  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

АУДИТЫН ГАЗАРТ

ЗДТГазрын 2016 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан дүгнэлт, зөрчлийн акт албан шаардлагуудтай танилцлаа.

Албан шаардлага акт тавигдсан зөрчлүүдийг хүлээн зөвшөөрч байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



ДАРГА О. Г. СҮНЭНБОР

0000194

СБА-2017/03-ГА  
Гүйцэтгэлийн аудитын тайлан

Сүхбаатар аймгийн Онгон сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/112

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай


Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, 11, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Сүхбаатар аймгийн Онгон сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар тогтоосон акт, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг дарга /О.Үнэнбор/-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

*Н.Болдбаатар*  
*А.Мөнхцэцэг*  
*Б.Мөнхбамбар*

Н.БОЛДБААТАР  
А.МӨНХЦЭЦЭГ  
Б.МӨНХБАМБАР

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

*М.Нарантуяа*  
*Г.Даваа*

Г.ДАВАА

